

# Өсөж хөгжих загвар

<p>Өөрийн хэрэгцээ, бэлэг, авьяасыг олж мэд. Дараахтай адил асуултуудыг тавихыг бод.</p> <p>Би амьдралдаа юу сурах эсвэл өөрчлөх хэрэгтэй гэж бодож байна вэ?</p> <p>Би ямар авьяас чадвартай болохыг хүсэж байна вэ?</p> <p>Би ямар сүнслэг дадлыг хөгжүүлж, сайжруулах хэрэгтэй байна вэ?</p> <p>Би баптисм хүртэхдээ байгуулсан гэрээнүүдээ хэрхэн сахиж чадах вэ?</p> <p>Би хэнд үйлчилж болох вэ?</p> <p>“Чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг . . . надаас асуух ёстой” (Сургаал ба Гэрээ 9:8).</p>	<p>Сайжрахаа төлөвлө. Дараахтай адил асуултуудыг тавихыг бод.</p> <ul style="list-style-type: none"><li>• Яагаад энэ нь миний хувьд чухал вэ?</li><li>• Энэ нь хэрхэн Есүс Христтэй илүү адил болоход надад туслах вэ?</li><li>• Би үүнд хүрэхийн тулд ямар ямар үйлдэл хийж чадах вэ?</li><li>• Би тэдгээр үйлдлээ илүү жижиг алхмуудад хувааж болох уу?</li><li>• Би тулгарч болох бэрхшээлийг даван туулахын тулд ямар төлөвлөгөө одоо гаргаж болох вэ?</li></ul> <p>“Христийн үгс [бидний] хийвэл зохих бүх зүйлийг [бидэнд] хэлэх болно” (2 Нифай 32:3).</p>
<p>Олж мэдсэн зүйлээ эргэцүүлэн бод. Дараахтай адил асуултуудыг тавихыг бод.</p> <ul style="list-style-type: none"><li>• Би ямар байдлаар өсөж хөгжсөн бэ?</li><li>• Би бусдад үйлчлэхийн тулд өөрийн сурсан зүйлийг хэрхэн ашиглаж болох вэ?</li><li>• Миний үйлдлүүд Аврагчтай илүү ойртоход хэрхэн надад тусалсан бэ?</li><li>• Би энэ тал дээр хэрхэн үргэлжлүүлэн өсөж хөгжиж болох вэ?</li></ul> <p>“Хөл доорх замаа дэнсэл” (Сургаалт үгс 4:26).</p>	<p>Итгэлээ өсгөн нэмэгдүүлэхийн тулд үйлд. Хэрвээ гацаанд орвол дараахтай адил асуултуудыг тавихыг бод.</p> <ul style="list-style-type: none"><li>• Юу нь болсон бэ? Яагаад?</li><li>• Юу нь болсонгүй вэ? Яагаад болоогүй вэ?</li><li>• Би өөр юуг оролдож үзэж болох вэ?</li><li>• Би хаанаас өөр санаа олж болох вэ?</li><li>• Би зорилгоо арай жижиг алхмуудад эсвэл үйлдлүүдэд хувааж болох уу?</li><li>• Би тохиолдсон саад тотгороос хэрхэн суралцаж болох вэ?</li></ul> <p>“Үнэнээр би хэлнэ, [чи] сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориулж, мөн чөлөөт хүсэл зоригоороо олон зүйлийг хий[х] . . . ёстой” (Сургаал ба Гэрээ 58:27).</p>